

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2022 ОНЫ 10 ДУГААР САРЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД

Аймгийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг 2 удаа зохион байгуулж, аймгийн Засаг даргаас 6 үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг тооцон ажилласан.

Аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлыг 1 удаа зохион байгуулан, 5 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

Дэлхийн багш нарын 28, Монголын багш нарын 56 дахь баярын өдөр, Монгол улсад орчин цагийн боловсролын салбар үүсэж хөгжсөний 101 жилийн ойн баярын хурлыг 2022 оны 10 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулсан. Баярын хурлын үеэр үр бүтээлтэй ажиллаж буй багш нарт салбарын болон аймгийн шагналыг гардуулсан. Мөн энэ үеэр Аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан “Чадварлаг багш журам”-ын дагуу гүйцэтгэлийн болон чанарын үнэлгээ, элсэлтийн ерөнхий шалгалтад амжилт гаргасан нийт 45 багшид нийт 16.1 сая төгрөгийн мөнгөн урамшуулал үзүүлсэн.

Монгол-Оросын найрамдлын өдрүүдийн хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газар, Найрамдлын нийгэмлэгүүдийн Монголын эвлэл, Русский дом в Уланбаторе (Улаанбаатар дахь Оросын Шинжлэх ухаан, соёлын төв РЦНК) хамтран зохион байгуулж буй “Орос хэлний бүсийн олимпиад, соёлын арга хэмжээ”-ний албан ёсны төлөөлөгчидтэй 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдөр уулзалт зохион байгуудсан. Уулзалтаар Оросын их дээд сургуулиудад аймгийн хүүхэд, залуусыг суралцуулах, Орос хэлний багш нарыг чадавхжуулах талаар санал солилцлоо.

Төрийн албаны ерөнхий шалгалт улсын хэмжээнд 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулагдсан. Аймгийн хэмжээнд төрийн албаны ерөнхий шалгалт өгөхөөр 39 иргэн бүртгүүлснээс 35 иргэн шалгалтад орж, 17 иргэн тэнцсэнээр нийт орсон иргэдийн 48.6 хувь нь шалгалтад тэнцсэн байна.

Төрөөс баримталж буй соёл урлагийн бодлогыг хэрэгжүүлэн төрийн албан хаагчдын цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хамт олонч нөхөрсөг байдлыг бий болгох, “БОРЖИГИН ӨВ” соёлыг түгээн дэлгэрүүлэн, урлагийн гоо зүйн боловсролыг дээшлүүлэх зорилгоор Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газар, Соёл, урлагийн газар, Боржигин чуулга хамтран “БОРЖИГИН ТҮМНИЙ ДУУЛАЛ 2022” урлагийн бага наадмыг 2022 оны 10 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд зохион байгууллаа. Тус наадамд 67 байгууллагын 15 багийн хамтарсан тоглолтонд 506 ажилтан, албан хаагчид оролцсон.

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, орлого бүрдүүлэлтийг эрчимжүүлэн төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэхэд анхаарч ажиллаж байна.

2022 оны 10 дугаар сарын нийт татварын орлогын төлөвлөгөө 8 532 693,9 мян төгрөг, гүйцэтгэлээр 7 208 448 мян төгрөг буюу 84.4%, үүнээс улсын төсвийн орлогын төлөвлөгөө 1 541 547.3 мян төгрөг төвлөрүүлэхээс хүлээгдэж буй гүйцэтгэлээр 2 182 637 мян төгрөг буюу 141.5%, сумын төсвийн орлогын төлөвлөгөө 5 218 216.5 мян төгрөг төвлөрүүлэхээс 4 578 818 мян төгрөг буюу 87.7%, аймгийн төсвийн орлогын төлөвлөгөө 1 982 791,1 мян төгрөг төвлөрүүлэхээс 1 251 943 мян төгрөг буюу 63.1%-ийн тус тус гүйцэтгэлтэй байна. 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар 642 хуулийн этгээд бүртгэлтэй байсан бол 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 692 болж өссөн байна. Үүнд: ХК-1, ХХК-358, ББН-5, ЗБН-9, Хоршоо- 29, ХЗХоршоо- 1, ОНӨҮГ- 6, Салбар-66, төсөвт болон төрийн бус байгууллага, сан ОНБ-217 байна.

Санхүүгийн хяналт, аудитын чиглэлээр:

Аймгийн хэмжээнд нийт төсвийн болон орон нутгийн өмчит 75 байгууллагын шилэн дансны хуулийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан. 2022 оны 09 сарын байдлаар шилэн

дансны хуулийн хэрэгжилт 95,1 хувьтай байна.Өмнөх сарын хэрэгжилттэй харьцуулахад 0.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Санхүүгийн хяналт, аудитын албанаас 10 дугаар сард аймгийн ОНХСангийн 2021 оны үйл ажиллагаа, Сүмбэр сумын ОНХСан, Талын илч ОНӨААТҮГ-ын 2021 оны үйл ажиллагаа, Тохижилт сүмбэр ОНӨААТҮГазрын 2021 оны үйл ажиллагаа, МУЗГазрын 2020 оны 211 дүгээр тогтоолоор айл өрх, албан байгууллага, аж ахуйн нэгжид цахилгаан, дулаан, уур ус, хогны үнийн хөнгөлөлт үзүүлсэнтэй холбоотой үйлчилгээ үзүүлсэн ААНэгжийн хөнгөлөлт, чөлөөлөлт, үйлчилгээний төлбөрийг нэхэмжилсэн тооцоонд санхүүгийн шалгалт, Ус-Ду ОНӨААТҮГазрын 2020-2021оны үйл ажиллагаанд тус тус хяналт шалгалт хийсэн.

Шалгалтаар илэрсэн зөрчлийн хүрээнд 20 зөвлөмж өгсөн. Сүмбэр сумын ЗДТГазрын 2020-2021 оны шалгалтаар 16 753,3 мян төгрөгийн зөрчил илрүүлж 313,0 мян төгрөгийн нөхөн төлбөрийн акт тогтоосон. Илчлэг шивээ ОНӨААТҮГазрын 2021 оны шалгалтаар 4 619,8 мян төгрөгийн зөрчил илэрснээс 1 195,2 мян төгрөгийн хугацаатай албан шаардлага, Шивээговь сумын ОНХСангийн 2020-2021 оны шалгалтаар 156 402,3 мян төгрөгийн зөрчил илрүүлж дээрх зөрчлийг дахин давтахгүй байх талаар зөвлөмж хүргүүлсэн.

ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Төрийн архив: Архивийн баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд 1 хөмрөгийн 5 хадгаламжийн нэгж, 121 заалт, 1091 хүний нэр, 129 байгууллагын нэр, 387 газарзүйн нэр, 675 хуудас баримтыг программд холбож ажилласан. 2022 оны 10 дугаар сард 12 иргэнд лавлагаа хуулбар гаргаж үйлчилгээ үзүүлсэн.

Улсын бүртгэл:

Улсын бүртгэлийн хэлтсээс 2022 оны 10 дугаар сард дараах чиглэлээр нийт 658 иргэнд төрийн үйлчилгээ үзүүлсэн байна. Үүнд:

Иргэний бүртгэлийн чиглэлээр:

- Шинээр гадаад паспорт захиалсан - 16
- Иргэний үнэмлэх шинээр олгосон - 34
- Төрснөө бүртгүүлсэн хүүхдийн тоо - 36
- Гэрлэлт бүртгүүлсэн тоо - 8
- Гэрлэлт цуцлуулснаа бүртгүүлсэн тоо - 1
- Үрчлэлтийн бүртгэлийн тоо - 0
- Овог, нэр өөрчлөлтийн бүртгэлийн тоо - 1
- Эцэг тогтоолтын бүртгэлийн тоо - 3
- Нас барсныг бүртгүүлсэн тоо - 9
- Өөр аймаг, хотоос шилжиж ирсэн нийт иргэн -18
- Аймаг дотор шилжсэн иргэдийн тоо –11
- Тоон гарын үсэг олголт- 89

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр:

- Үл хөдлөх хөрөнгийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 6
- Газар өмчлөх эрхийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 45
- Гэрээний бүртгэл - 59
- Барьцааны гэрээний бүртгэл - 108
- Эд хөрөнгөд орсон өөрчлөлт, залруулга - 6

Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр

- Шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн бүртгэл - 11
- Хуулийн этгээдийн бүртгэлийн өөрчлөлт - 6

Архивын чиглэлээр:

- Иргэнд гаргасан лавлагаа, хуулбар - 191

Нийт үзүүлсэн үйлчилгээ-658

Хууль сахиулах чиглэлээр: 2022 оны 10 дугаар сард иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 101 гомдол, мэдээллийг хүлээн авч шалгаснаас гэмт хэргийн 25, зөрчлийн 76 гомдол мэдээлэл байна. Тайлангийн хугацаанд зөрчил үйлдсэн 15 иргэнийг эрх бүхий албан тушаалтнаас болон шүүхээс 2 300 000 төгрөгөөр торгож, согтуугаар зөрчил гаргасан 22 хүнийг эрүүлжүүлж, 18 хүнийг шүүхээр баривчлуулан, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 42 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хассан байна.

Хариуцсан нутаг дэвсгэрийн эрүү, хэв журмын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор давхардсан тоогоор худалдаа, үйлчилгээний үйл ажиллагаа эрхэлдэг 126 цэгийн үйлчилгээний цагийн хуваарьт өдөр тутам хяналт шалгалт хийж, зөвлөгөө өгч ажилласан.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр гудамж талбай, олон нийтийн газарт гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр Сүмбэр, Баянтал, Шивээговь сумын нутаг дэвсгэрт эргүүлийг тасралтгүй зохион байгуулж, давхардсан тоогоор 172 алба хаагч эргүүлийн үүрэг гүйцэтгэж, гудамж талбай, олон нийтийн газар болон авто замд зөрчил гаргасан 2029 хүнийг 56 135 500 төгрөгөөр торгож ажиллалаа.

Тайлант сард гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг цахим хэлбэрээр олон нийтэд хүргэх, хууль сурталчилах, ухуулах, цаг үеийн болон нөхцөл байдлын талаарх мэдээ мэдээллийг түгээх ажлыг тасралтгүй зохион байгуулж, төв, орон нутгийн холбогдох байгууллагаас цахим орчинд нийтлэсэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх санамж, анхааруулга, зөвлөмж 31, видео шторк 29, бусад 21 нийт 81 мэдээллийг "Говьсүмбэр аймаг дахь цагдаагийн хэлтэс" пэйж хуудсанд байршуулж, иргэд, олон нийтэд түгээсэн.

Цагдаагийн байгууллагаас улсын хэмжээнд зохион байгуулж байгаа эзэн холбогдогч нь тогтоогдоогүй, нууц далд аргаар үйлдэгдсэн гэмт хэргийг нөхөн илрүүлэх, холбогдогчийг олж тогтоох зорилгоор "Илрүүлэлт-оргодол" нэгдсэн арга хэмжээ, хүүхдийг бэлгийн хүчирхийлэл, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, далд хэлбэрээр үйлдэгдсэн хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн талаар мэдээлэл, цуглуулах, илрүүлэх, шалган шийдвэрлэх зорилгоор "Нуугдмал" арга хэмжээг хариуцсан нутаг дэвсгэрт зохион байгуулж байна. Сүмбэр сумын 3-р багийн нутаг дэвсгэрт аж ахуй нэгж, байгууллагын гадна болон дотор орчны камерын үйл ажиллагааг шалгаж, ажилчдын судалгааг "Камер-хяналт" хэсэгчилсэн арга хэмжээ авч ажиллалаа. Сүмбэр сумын Хамтарсан багаас санаачилсан гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийн хор уршгийг талаарх иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх, хүчирхийллийг үл тэвчих нийгмийн хандлагыг төлөвшүүлэх, нуугдмал хэрэг, зөрчлийг илрүүлэх, хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээхэд дэмжлэг үзүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор "Хүчирхийлэлгүй гэр бүл-Хүчирхийлэлгүй ирээдүй" аяныг хамтран хэрэгжүүлж эхлээд байна.

Онцгой байдлын газар нь: Аймгийн хэмжээнд гал түймрийн объектын дуудлага 3 удаа бүртгэгдэж мөн галт зэвсэгийн 1 дуудлага бүртгэгдсэн байна.

Шадар сайд, Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн хүрээнд Гэр хорооллын айл өрх, барилгын материал, мод модон эдлэлийн барилга байгууламжид төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт, шалгалтыг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 05-ны өдрүүдэд зохион байгуулж байна.

Гэр хорооллын айл өрхүүдэд галын аюулаас урьдчилан сэргийлэх удирдамжийн хүрээнд иргэн, аж ахуй нэгж байгууллагад галын аюулгүй байдлыг хангуулах урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт хяналт шалгалт зохион байгуулсан бөгөөд нийт 1538 айл өрх хамрагдаж, 413 зөрчил дутагдлыг илрүүлж, газар дээр нь 302 зөрчлийг арилгуулж, 111 зөрчил дутагдлыг эргэн шалгах хугацаатай заавар зөвлөмж өгч 7780 иргэнд галын аюулаас урьдчилан сэргийлэх ухуулга сурталчилгаа хийсэн.

Сүмбэр, Шивээговь, Баянтал сумдад Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн мэдэгдэл эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж, хэрэгжилтийг хангуулж байна.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2021 оны А/154 дүгээр тушаалаар батлагдсан “Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргах журам”-ын 1 дүгээр хавсралтыг үндэслэн 9 иргэн, аж ахуй нэгж байгууллагын гаргасан хүсэлтийн дагуу галын аюулгүй байдлыг шалган илэрсэн зөрчил дутагдалд мэргэжил арга зүйн зөвлөмж өгч, ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт олгож, 200,000 төгрөгийг тэмдэгтийн хураамжийн хуулийн дагуу орон нутгийн орлогод төвлөрүүлсэн.

ДӨРӨВ. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Боловсролын чиглэлээр: Боловсролын чанарын шинэчлэл төслийн санхүүжилтээр “Тоглонгоо суралцъя” дугуйланг ажиллуулж байна. Тус дугуйланд Сүмбэр сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2-5 дугаар ангийн 45 хүүхэд хамрагдсан.

2022-2023 оны хичээлийн жилийн 1 дүгээр улирлын оношлох үнэлгээг ерөнхий боловсролын сургуулийн 2-5 дугаар ангийн нийт сурагчдыг хамруулан Монгол хэл, Математикийн хичээлээр зохион байгуулж, үр дүнгийн хурал, цаашид сурлагын хоцрогдлыг арилгах төлөвлөгөөг хэлэлцлээ.

2022 оны ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн чанарын үнэлгээг 2022 оны 10 дугаар сарын 17-20-ны өдрүүдэд “Боловсролын үнэлгээний төв”-тэй хамтран зохион байгууллаа. Чанарын үнэлгээнд Сүмбэр сумын ерөнхий боловсролын 1, 5 дугаар сургууль, Шивээговь сумын 3 дугаар сургуулийн 6, 10, 12 дугаар ангийн сурагчдыг хамруулан түүврээр зохион байгуулсан.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиглэлээр: “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд нийгэмд тулгамдаж буй хөгжлийн асуудлуудыг шийдвэрлэхэд залуучуудын дуу хоолой, үзэл бодол, бүтээлч санаачилга, шийдлийг дэмжиж, чадавхжуулах зорилгоор улсын хэмжээнд зохион байгуулагдаж байгаа “Шинэ сэргэлт-Next gen 2022” төслийн уралдаанд орон нутгаас 23 иргэн бүртгүүлсэн.

Олон улсын охидын эрхийг хамгаалах өдрийн хүрээнд Монголын эмэгтэйчүүдийн холбоо, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран “Нандин” хүүхдийн чуулган Төрийн ордонд 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулагдсан. Тус чуулганд аймаг орон нутгаа төлөөлөн 5 сургуулийн 20 сурагч, 5 нийгмийн ажилтан, 1 сэтгэл зүйч оролцсон.

Соёл, урлагийн чиглэлээр: Соёл, урлагийн газар нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн газрын даргын 2022 оны А/14 тоот тушаал, аймгийн Засаг даргын А/256 тоот захирамжийн дагуу улсын тооллогын ажлыг 2022 оны 10 дугаар сарын 3-ны өдрөөс 8-ны өдрүүдэд зохион байгууллаа. Тооллогоор улс, аймаг, сумын хамгаалалттай 84 дурсгалт газрын 624 дурсгалыг тоолж бүртгэн баримтжуулан программд оруулсан.

Биеийн тамир, спортын чиглэлээр: Зүүн бүсийн Биеийн тамир, спортын газруудын сургалт, уулзалт, зөвлөгөөн 2022 оны 10 дугаар сарын 5-7-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. Уг зөвлөгөөнд Дорнод, Сүхбаатар, Дорноговь, Хэнтий, Говьсүмбэр аймгийн биеийн тамир, спортын газрын албан хаагчид, дасгалжуулагч, багш нар хамрагдсан. Нийт 80 албан хаагч хамрагдсан.

Усанд сэлэлтийн 30 дахь удаагийн улсын аварга шалгаруулах тэмцээнд Говьсүмбэр аймгийн баг тамирчид амжилттай оролцож 1 мөнгө, 3 хүрэл медаль, Сонгино хайрхан дүүрэг 30 жил, “Макс групп”-ын 30жил, “МJ Cup-2022 “ өсвөр үеийн жудо бөхийн олон улсын тэмцээнд 50 байгууллагын 1000 гаруй тамирчид оролцсоноос 8 тамирчин оролцож, -70кг жинд хүрэл медаль, Сагсан бөмбөгийн U14 насны улсын аварга шалгаруулах тэмцээнд 10 багаас охидын баг 3 дугаар байрт шалгарсан.

Эрүүл мэндийн чиглэлээр:

| Үзүүлэлт | 2021 оны 10 сар | 2022 оны 10 сар |
|-------------------------------------|-----------------|-----------------|
| Төрсөн эх | 395 | 297 |
| Гэрийн төрөлт | 3 | 2 |
| Амьд төрсөн хүүхэд | 401 | 295 |
| Амьгүй төрөлт | 1 | 3 |
| Нас баралт | 71 | 71 |
| Эмнэлгийн нас баралт | 23 | 20 |
| Хоног болоогүй нас баралт | 6 | 7 |
| 0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл | 1 | 4 |
| 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл | 0 | 1 |
| Эмнэлгээс гарсан хүний тоо | 5759 | 4332 |
| Амбулаторийн үзлэг | 83011 | 85123 |
| Халдварт өвчин | 4190 | 2528 |

Орон нутгийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн хорт хавдрын эрт илрүүлэг, оношилгоо, эмчилгээний чадавхийг дээшлүүлэх, тэдний хорт хавдраас сэргийлэх, хянах талаар олон нийтэд сургалт, сурталчилгаа хийх ур чавдар, арга зүйг сайжруулах хүрээнд хамтарсан үзлэг, оношилгоо болон эсийн шинжилгээ хийх чиглэлээр “Хөнгөвчлөх тусламж үйлчилгээ ба хорт мансууруулах эмийн хэрэглээ”, “Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлгийн эсийн шинжилгээ авах арга” сэдэвт ажлын байрны сургалтыг зохион байгууллаа.

Мөн урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийг сайжруулах арга хэмжээг бодлогоор дэмжин аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгаж, Хавдар судлалын үндэсний төвийн нарийн мэргэжлийн эмч нарын багийг 4 дэх жилдээ урьж ажиллуулан эрсдэлт бүлгийн хүн амын дунд үзлэг, шинжилгээг зохион байгуулан ажилласан.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний чиглэлээр: Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан зөвлөгөөг ажилгүй, ажил хайгч, ажил олоход хүндрэлтэй 5 иргэнд үзүүлсэн. Тайлант хугацаанд 2019-2022 онд ХЭД хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 149 иргэний эргэн төлөлтөд хяналт тавьж, 78 хүний 22 324,0 мян төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлэн ажилласан.

E-HALAMJ цахим систем болон уламжлалт аргаар нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж, үйлчилгээг иргэдэд үзүүлсэн.

Зорилтот бүлгийн иргэдэд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг 803 иргэнд цаг тухайд нь олгож, түргэн шуурхай үйлчилсэн. Үүнд:

- Халамжийн тэтгэврийг 284 иргэнд,
- Асаргааны мөнгөн тэтгэмжийг 265 иргэнд,
- Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг 254 иргэнд үйлчилгээ үзүүлсэн.

ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

2021 оны жилийн эцсээр нийт 432.2 мян.тол мал тоолуулж, 2022 оны хавар 153.9 мян.тол төл бойжуулсан. Төлийн орлого, зүй бус хорогдол, эдийн засгийн эргэлтэд оруулах, хүнсэнд хэрэглэх малыг тооцоолоод хонин толгойд шилжүүлснээр 683.5 мян.тол мал өвөлжиж, хаваржихаар байна. Энэ жил эдийн засгийн эргэлтэд 133.2 мян.тол мал оруулахаар тооцсон бөгөөд хүнсний хэрэгцээнд нийт 2.7 мян.тол мал бэлтгэсэн байна.

Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар инженерийн хийцтэй 4 худаг шинээр гаргах ажил үргэлжилж байна. Сүмбэр суманд 2 худаг, Баянтал суманд 1, Шивээговь суманд 1 худаг тус тус гаргахаар өрөмдлөгийн ажил хийгдэж байна.

Хоршоодын хөгжлийг дэмжих жилийн хүрээнд биржийн үйл ажиллагааг сурталчлан таниулах, хоршоо биржээр дамжуулан арилжаанд оролцох талаар мэдээлэл өгөх,

стандартын шаардлага хангасан агуулахыг итгэмжлэх, гэрээ байгуулах, биржийн байнгын бус гишүүнээр хоршоог бүртгэх мэдээлэл, сургалтыг Хөдөө аж ахуйн биржтэй хамтран 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан. Тус сургалтад түүхий эд бэлтгэн нийлүүлэгч, хоршооны төлөөлөл нийт 20 хүн оролцсон. Хөдөө аж ахуйн биржээр дамжуулан арилжаанд оролцохоор орон нутгийн 4 хоршоо гэрээ хийлээ.

2022 онд 21 га-аас 177 тн төмс, 31.2 га-аас 247.6 тн хүнсний ногоо хураан авсан дүнтэй байна. Энэ нь тухайн жилийн төлөвлөснөөс төмсний тариалсан талбайг 2 га-аар, хүнсний ногооны тариалсан талбайг 4.2 га-аар нэмэгдүүлсэн байна.

Хүнсний нөөц: Аймгийн хэмжээнд мах 12.4 тн буюу 10, гурил 55.1 тн буюу 53, сүү 3.6 тн буюу 2, төрөл бүрийн будаа 20.7 тн буюу 28, төмс 12 тн буюу 8, хүнсний ногоо 13.7 тн буюу 4, элсэн чихэр 8.3 тн буюу 18, давс 6.1 тн буюу 22, савласан ус 25 тн буюу 1, өндөг 3 тн буюу 11, ургамлын тос 7.9 тн буюу 25 хоногийн нөөцтэй байна

Дээрх нөөцийг сумдаар харуулбал: /2022.10.19-ний 18.00 цагийн байдлаар/

| № | Хүнсний нэр төрөл | Сүмбэр сум | | | Баянтал | | Шивээговь | |
|----|----------------------|-------------|------------|---------------|------------|---------------|------------|---------------|
| | | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Хоногийн нөөц | Тоо хэмжээ | Хоногийн нөөц | Тоо хэмжээ | Хоногийн нөөц |
| 1 | Малын мах | тн | 7.1 | 6 | 1.1 | 137.1 | 4.2 | 14 |
| 2 | Гурил | тн | 51 | 63 | 1.8 | 14.3 | 2.3 | 16 |
| 3 | Гурилан бүтээгдэхүүн | тн | 3.2 | 0.9 | 0.40 | 1.6 | 1.4 | 3 |
| 4 | Төрөл бүрийн будаа | тн | 16 | 23 | 2.1 | 30.7 | 2.6 | 31 |
| 5 | Сүү | тн | 3.4 | 1 | 0.20 | 1.4 | 2.2 | 5 |
| 6 | Өндөг | тн | 1.3 | 6 | 1.20 | 65.8 | 0.5 | 9 |
| 7 | Ургамлын тос | тн | 6.1 | 26 | 0.20 | 9.5 | 1.6 | 24 |
| 8 | Төмс | тн | 8.1 | 4 | 1.8 | 2.7 | 2.1 | 11 |
| 9 | Хүнсний ногоо | тн | 9.1 | 3 | 1.7 | 1.3 | 2.9 | 3 |
| 10 | Элсэн чихэр | тн | 6 | 18 | 0.50 | 16.6 | 1.8 | 19 |
| 11 | Давс | тн | 5.2 | 26 | 0.40 | 21.9 | 0.5 | 9 |
| 12 | Савласан цэвэр ус | тн | 15 | 1 | 1.00 | 0.7 | 9 | 2 |

Аймгийн төвийн захууд, томоохон худалдааны төвүүдийн хүнсний бараа, бүтээгдэхүүний үнийг өнгөрсөн сарын үнэтэй харьцуулан гаргасан 2022 оны 10-р сарын үнийн мэдээ:

Зах зээлд худалдаалагдаж буй зарим хүнсний бараа бүтээгдэхүүний үнэ өнгөрсөн сараас 250-500 төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Тухайлбал: Үхрийн мах, ямааны мах, хонины мах тус бүр 500 төгрөгөөр, төмс 250 төгрөгөөр, сонгино 250 төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Бусад бараа бүтээгдэхүүний үнэ тогтвортой байна. Үнийн мэдээг Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад дотооддоо үйлдвэрлэж буй малын мах төрөл тус бүрээр 250-500 төгрөгөөр, төмс, хүнсний ногоо 50-100 төгрөгөөр, сүү 500 төгрөгөөр, гурил 50-150 төгрөгөөр буурсан бол импортын бүтээгдэхүүн болох элсэн чихэр 200 төгрөгөөр, цагаан будаа 500-1000 төгрөгөөр, ургамлын тос 1000-1500 төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

| № | Бараа бүтээгдэхүүн | Дээд үнэ | Доод үнэ | Өссөн буурсан |
|---|--------------------|----------|----------|---------------|
|---|--------------------|----------|----------|---------------|

| | | | төг | төг | |
|----|---------------------|----------------------------|-------|-------|------|
| 1 | Үхрийн мах | Ястай | 10000 | 9500 | -500 |
| | | Цул | 12000 | 8000 | -500 |
| 2 | Хонины мах | Ястай | 5000 | 4500 | -500 |
| | | Цул | 10000 | 10000 | -500 |
| 3 | Адууны мах | Ястай | 8000 | 6500 | |
| | | Цул | 9000 | 9000 | |
| 4 | Ямааны мах | Ястай | 6000 | 4500 | -500 |
| | | цул | 8000 | 8000 | -500 |
| 5 | Тахианы мах | Гуя | 12000 | 10500 | |
| | | мөч | 14300 | 11000 | |
| 6 | Лууван | монгол | 2500 | 2000 | |
| | | хятад | | | |
| 7 | төмс | монгол | 500 | 500 | -250 |
| | | хятад | | | |
| 8 | Байцаа | монгол | 1500 | 1600 | |
| | | хятад | | | |
| 9 | чинжүү | монгол | | | |
| | | хятад | 5000 | 8500 | |
| 10 | Манжин | монгол | 2800 | 1400 | |
| | | хятад | | | |
| 11 | Сонгино бөөрөнхий | Монгол | 2000 | 2000 | -250 |
| | | Хятад | | | |
| 12 | Помидор | монгол | 6500 | 6000 | |
| 13 | Өргөст хэмх | монгол | 6500 | 6000 | |
| 14 | Элсэн чихэр | монгол | 3300 | 2900 | |
| 15 | Будаа | Цагаан задгай кг | 3800 | 3000 | |
| | | Шар слава кг | 5100 | 3000 | |
| | | Гурвалжин будаа кг | 6000 | 4000 | |
| 16 | Сүү | Задгай | 3000 | 2800 | |
| | | Сүү ХХК 0,5л | | | |
| | | Сүү ХХК 1л | 4300 | 4000 | |
| 17 | Тараг | Задгай | 3500 | 3000 | |
| | | Сүү ХХК 1л цөцгийтэй тараг | 5500 | 3800 | |
| 18 | Талх | Чойр талх | 1900 | 1500 | |
| 19 | Өндөг | ОХУ | 400 | 330 | |
| | | Монгол | 450 | 400 | |
| 20 | Алтан тарианы гурил | Задгай дээд | 1500 | 1300 | |
| | | Задгай 1-р зэрэг | 1560 | 1400 | |
| | | Задгай 2-р зэрэг | 1400 | 1000 | |
| | | Савласан д/дээд / | 2400 | 2400 | |
| | | Савласан дээд | 2200 | 1800 | |
| | | Савласан 1-р зэрэг | 1600 | 1400 | |
| | | Савласан 2-р зэрэг | 1200 | 1000 | |

| | | | | | |
|----|--------------|----------------|-------|------|--|
| 21 | Ургамлын тос | Олейна | 10000 | 9500 | |
| | | Алтан | 8000 | 7500 | |
| 22 | Гоймон | Алейка | 2800 | 2000 | |
| | | А/тариа савхан | 1800 | 1000 | |

ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Байгаль орчны чиглэлээр: Аймгийн аялал жуулчлал, худалдаа, үйлчилгээний байгууллагын бизнесийн гадаад, дотоод орчны шинжилгээ, амжилтанд нөлөөлөх хүчин зүйлүүдийн шинжилгээг хийж, баримтлах стратегиудыг тодорхойлж, компани бүр өөрсдийн оролцоог тодорхойлон хамтран хөгжих стратеги, бодлогоо тодорхойллоо. Аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага” сэдэвт телевизийн хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Сүмбэр сумын Засаг дарга, аймгийн аялал жуулчлалын холбоо, Боржигин голомт жуулчны бааз, Оорцог элгэн хоршоо зэрэг байгууллагуудын төлөөлөл оролцсон.

Сүмбэр сумын ерөнхий боловсролын лаборатори 5-р сургуулийн 9а ангийн сурагчид, “Аргал Ойл” ХХК-ийн ажилтнуудад “Хог хаягдлыг ангилан ялгах” дадал хэвшил бий болгох сургалт зохион байгууллаа. Мөн аймгийн Онцгой байдлын газартай хамтран айл өрхүүдэд “Яндангаа хөөлье”, “Өнтэй өвөлжье”, “Хог хаягдлаа ангилан ялгая” зэрэг гарын авлага тараасан.

“Ногоон ажлын байр” төсөл, хөтөлбөрийн хүрээнд нийт 90 иргэнийг түр ажлын байраар хангаж мод тарих, тарьсан мод бутгаа услах зэрэг ажлыг гүйцэтгүүлсэн. Намрын мод бутны үзэсгэлэн худалдааг 2022 оны 10 дугаар сарын 7-ны өдөр зохион байгууллаа. Үзэсгэлэн худалдаанд Сум дундын Ойн анги, “Модны их ургац” нөхөрлөл оролцсон бөгөөд сум дундын Ойн анги 731 ширхэг хайлаас, 33 ширхэг шар хуайс, 87 ширхэг бургас мод бутыг 7 аж ахуйн нэгж, байгууллага, 2 иргэнд худалдан борлуулсан.

Байгаль орчин, аялал жуулчлалын газар, аймгийн аялал жуулчлалын холбоотой хамтран үйлчилгээний ажилтнуудад зориулсан “ЁС ЗҮЙ, ХАРИЛЦАА ХАНДЛАГА” сэдэвт сургалтыг зохион байгуулав. Сургалтанд жуулчны бааз, зочид буудал, худалдаа үйлчилгээний салбарын нийт 27 хүн хамрагдсан.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, хөрөнгө оруулалтын талаар: Сүмбэр сумын 5, 6 дугаар багийн нутаг дэвсгэрт тариалангийн бүс бий болгохоор 2022 оны 10 дугаар сарын 06-ны өдөр Уул худаг, Шар хад хэмээх газарт хээрийн судалгаа, хэмжилтийн ажлыг хийж, ажлын үр дүнг холбогдох аймаг, сумын удирдлагуудад танилцууллаа. Газрын төлбөрийн орлого 360 сая.төг төвлөрүүлэхээс 2022 оны 10 дугаар сарын байдлаар 191.75 сая.төг буюу 53.2%-ийн орлого төвлөрсөн байна.

Орон нутгийн өмч, худалдан авах ажиллагааны талаар: 10 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар түрээсийн орлого 20.9 сая төгрөг төвлөрөөд байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчид 2022 онд нийт 15,815,162.8 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 49 бараа, ажил, үйлчилгээ худалдан авч хэрэгжүүлэхээр төлөвлөн ажилласан байна. Үүнээс 48 тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр зарласан. Худалдан авах ажиллагааны явц 100 хувьтай байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 5 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 5 ажил буюу 100%, Орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийт 25 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 25 ажил буюу 100%, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар нийт 16 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 16 ажил буюу 100%, Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар нийт 2 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 2 ажлын тендер шалгаруулалтыг, Авто замын сангийн хөрөнгө оруулалтаар нийт 1 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 1 ажлын тендер шалгаруулалтыг тус тус цахимаар зохион байгуулаад байна.

Баянтал сум: “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд Баянтал сум 300 мод тарьж намрын тариалалтаа хийж гүйцэтгэлээ.

Шивээговь сум: 2022 оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлага 10 дугаар сарын 12-ны өдөр сумын хэмжээнд зохион байгуулагдлаа. “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан “Сайн засаглал”, “Ухаалаг засаглал”, “Цахим засаглал”-ыг бий болгох зорилтын хүрээнд төрийн үйлчилгээг цахимжуулах ажлын хүрээнд иргэдэд өөртөө үйлчлэх цахим цэгийг бий болгон сумын Засаг даргын Тамгын газрын нэгдсэн үйлчилгээний төвд байршуулан ажиллаж байна.

Сүмбэр сум: Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд багийн Засаг даргын тодорхойлолтыг 308 иргэнд, хөнгөлөлт тусламж 7 иргэнд хүргэж, ХАӨМС-ын программын 45 өрхийн алдааг засан, шинээр төрсөн хүүхэд болон нас барсан, шилжиж ирсэн, шилжиж явсан хүмүүсийн мэдээллийг программд тухай бүр бүртгэж, хасалт хийж ажилласан. Сүмбэр сумын 1, 2 дугаар багийн нийтийн эзэмшлийн гудамж талбай, хүүхдийн тоглоомын талбайд хөрсний ариутгал, халдваргүйжүүлэлтийг хийсэн. Отор, нүүдлийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, отроор орж ирсэн айл өрхүүдтэй уулзаж “Бэлчээр ашиглалтын журам”-ыг танилцуулан, отроор орж ирсэн 3 айл өрхөд дамжин өнгөрөх маршрутыг танилцуулсан. 2022 оны хоёрдугаар ээлжийн цэрэг 10 дугаар сарын 14-ний өдөр сумын хэмжээнд зохион байгуулагдлаа. Сумын хэмжээнд 18-25 насны 122 иргэн биеэр хамрагдаж 66.3 хувийн гүйцэтгэлтэй.

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР